

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19
5	Хавсралт.....	20
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
ш	ширхэг



「 БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
САНГИЙН ЗАХИРАЛ Х. ГАНБААТАР
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.25 № 06/563
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


071466

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сангийн захирал Х.Ганбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Сангийн захирал санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 27-ноос 2019 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, сангийн захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа, Э.Энхбаатар нар хэрэгжүүлэв.

Байгаль орчин, уур амьсгалын сан 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 102 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд

тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Байгаль орчин, уур амьсгалын сан “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн төлөв байдлыг судлан тогтоох, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, өөрчлөлтөд дасан зохицох, иргэдэд экологийн боловсрол олгох зэрэг чиглэлээр сангийн хөрөнгийг оновчтой, үр ашигтай зарцуулахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Үйл ажиллагаа:

Байгаль орчин, уур амьсгалын сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acoulous 3.0” програм хангамж ашигладаг байна.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Байгаль орчин, уур амьсгалын сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын суурийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны нийт зардал 4,805.5 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 48.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэлийг дунд гэж тодорхойлсонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/сая төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	33.1	
	Дүн	2	33.1	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Санхүүгийн тайлангийн залруулга

Биет бус хөрөнгө буюу санхүүгийн програм хангамжийг бүртгэлд авахдаа аж ахуйн материалд орлого авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд 0.9 сая төгрөгийн алдааг залруулсан.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Арабын Нэгдсэн Эмират Улсын 1.0 сая ам.доллар буюу 2,410.9 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах төслийн зардлын хуваарийг БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 07-

ны өдрийн А/420 дугаар тушаалаар өөрчилж агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн дэвшилтэт технологи /цахилгаан халаагуур/ нэвтрүүлэх ажлын зардлыг 1,200.0 сая төгрөг болгож 383.0 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Төслийн санхүүжилтийн санамж бичигт заасан Эрүүл мэнд-Интернейшнл байгууллагын нийлүүлж байгаа цахилгаан халаагуурын нийлүүлэлт, зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 37 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,881.4 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,557.4 сая төгрөг буюу 82.8 хувьтай байгаа нь тайлант онд төлөвлөсөн ажил бүрэн хийгдээгүйгээс шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Байгаль орчин, уур амьсгалын сан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Байгаль орчин уур амьсгалын сан нь тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 149 мэдээлэл оруулснаас хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 5, төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 1 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд

алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Байгаль орчин, уур амьсгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Өр төлбөртэй холбоотой

1.1 Илрүүлэлт

Тус сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй өр төлбөр нь 2014 оноос он дамжин бүртгэгдэж байгаа ба тайлант онд 12.8 сая төгрөгийг барагдуулж 279.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Өр төлбөрийн үлдэгдэлтэй харилцагч нарт тооцоо нийлэх хүсэлт явуулснаас 33.1 сая төгрөгийн авлагатай 5 харилцагч тус сантай тооцооны үлдэгдэлгүй талаар албан бичиг ирүүлсэн байна.

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Эрсдэл

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

1.3 Өгсөн зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах,

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах төсөл

2.1 Илрүүлэлт

Эко халаагуур нийлүүлэх тухай 2018 оны 18/350 дугаартай гэрээгээр Эрүүл мэнд-Интернейшнл байгууллагаас 2 загварын цахилгаан халаагуур нийт 622 ш хүлээн авахаас одоогийн байдлаар 500 ш хүлээн авч 122 ш эко цахилгаан халаагуур дутуу байна.

Мөн тайлант хугацаанд БЗД, БГД-ийн 200 оршин суугчидтай гэрээ байгуулж эко халаагуур олгосныг тулган шалгахад баримт материал дутуу 2 хүн байна.

Аудитын явцад тооллого хийж баталгаажуулахад зөрүү гараагүй боловч эко халаагуурыг зарцуулах бүрт үлдэгдлийг тоолж няравтай хүлээлцдэггүй байна.

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” хөрөнгө төлбөр тооцооны тооллогыг хийнэ гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Эрсдэл

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хөрөнгө дутагдах

2.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” хөрөнгө төлбөр тооцооны тооллогыг хийнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,043,338.00	27,538,151.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	5,043,338.00	27,538,151.00
354	Хангамжийн материал	5,043,338.00	27,538,151.00
35420	Аж ахуйн материал	5,043,338.00	27,538,151.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	23,256,365.20	20,378,869.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	23,256,365.20	20,378,869.90
392	Биет хөрөнгө	23,256,365.20	19,478,869.90
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,409,752.91	11,409,752.91
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,140,975.30	-2,281,950.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,135,000.00	4,135,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,759,166.74	-2,586,166.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,522,200.00	14,522,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,910,445.67	-5,719,965.63
393	Биет бус хөрөнгө	-	900,000.00
39301	Програм хангамж		900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	28,299,703.20	47,917,020.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	292,004,278.00	279,204,278.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	292,004,278.00	279,204,278.00
413	Өглөг	292,004,278.00	279,204,278.00
4136	Бусад өглөг	292,004,278.00	279,204,278.00
41361	Байгууллагад төлөх өглөг	292,004,278.00	279,204,278.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-263,704,574.80	-231,287,257.10
51	Засгийн газрын хувь оролцоо	-263,704,574.80	-231,287,257.10
512	Хуримтлагдсан үр дүн	-263,704,574.80	-231,287,257.10
51210	Өмнөх үеийн үр дүн	-263,704,574.80	-262,804,574.80
51220	Тайлант үеийн үр дүн		31,517,317.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	28,299,703.20	47,917,020.90

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,463,751,740.73	4,837,115,108.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	177,548,551.91	493,879,229.44
120	Нийтлэг татварын бус орлого	177,548,551.91	493,879,229.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,409,752.91	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,409,752.91	
120009	Бусад орлого	166,138,799.00	493,879,229.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,286,203,188.82	4,343,235,879.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,286,203,188.82	1,740,473,790.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,031,625,796.00	1,740,473,790.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	254,577,392.82	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,602,762,089.36
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		2,602,762,089.36
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,850,001,637.12	4,805,597,791.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,850,001,637.12	4,805,597,791.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,454,103,684.30	3,060,725,504.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	127,328,774.00	106,309,189.00
210101	Үндсэн цалин	116,952,074.00	25,345,508.00
210102	Нэмэгдэл	3,894,300.00	74,360,681.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,482,400.00	6,603,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,978,100.00	9,517,964.00
210201	Тэтгэврийн даатгал	6,017,620.00	5,917,564.00
210202	Тэтгэмжийн даатгал	792,096.00	900,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	990,120.00	720,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	198,024.00	180,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,980,240.00	1,800,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,919,000.00	89,919,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,353,600.00	1,353,000.00
210304	Байрны түрээс	88,565,400.00	88,566,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,166,174.00	12,607,212.00
210401	Бичиг хэрэг	2,634,900.00	2,641,412.00
210402	Тээвэр, шатахуун	5,911,450.00	4,445,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,619,824.00	5,520,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,850,000.00	7,347,300.00
210604	Урсгал засвар	9,850,000.00	7,347,300.00
2107	Томилолт, зочны зардал	3,744,100.00	614,400.00
210702	Дотоод албан томилолт	3,744,100.00	614,400.00

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,086,562,625.00	2,663,250,282.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,086,562,625.00	2,662,854,282.00
210803	Даатгалын үйлчилгээ		396,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,554,911.30	171,160,157.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-6,099,640.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	114,877,056.00	167,382,662.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,777,495.30	3,777,495.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	395,897,952.82	1,744,872,286.80
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	395,897,952.82	1,744,872,286.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	395,897,952.82	1,744,872,286.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-386,249,896.39</u>	<u>31,517,317.70</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-386,249,896.39</u>	<u>31,517,317.70</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,452,341,987.82</u>	<u>4,837,115,108.80</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,286,203,188.82	4,343,235,879.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,286,203,188.82	1,740,473,790.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,031,625,796.00	1,740,473,790.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	254,577,392.82	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,602,762,089.36
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		2,602,762,089.36
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,452,341,987.82</u>	<u>4,837,115,108.80</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,452,341,987.82	4,837,115,108.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,056,444,035.00	3,092,242,822.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	127,328,774.00	106,309,189.00
210101	Үндсэн цалин	116,952,074.00	25,345,508.00
210102	Нэмэгдэл	3,894,300.00	74,360,681.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,482,400.00	6,603,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,978,100.00	9,517,964.00
210201	Тэтгэврийн даатгал	6,017,620.00	5,917,564.00
210202	Тэтгэмжийн даатгал	792,096.00	900,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	990,120.00	720,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	198,024.00	180,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,980,240.00	1,800,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,919,000.00	89,919,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,353,600.00	1,353,000.00
210304	Байрны түрээс	88,565,400.00	88,566,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,100,174.00	14,902,025.00
210401	Бичиг хэрэг	2,568,900.00	4,936,225.00
210402	Тээвэр, шатахуун	5,911,450.00	4,445,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,619,824.00	5,520,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,850,000.00	7,347,300.00
210604	Урсгал засвар	9,850,000.00	7,347,300.00
2107	Томилолт, зочны зардал	3,744,100.00	614,400.00
210702	Дотоод албан томилолт	3,744,100.00	614,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,478,815,581.00	2,696,250,282.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,478,815,581.00	2,695,854,282.00

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ		396,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	322,708,306.00	167,382,662.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	207,831,250.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	114,877,056.00	167,382,662.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	395,897,952.82	1,744,872,286.80
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	395,897,952.82	1,744,872,286.80
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	395,897,952.82	1,744,872,286.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
C07	Тайлант үеийн үр дүн			0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	-263,704,574.80	-263,704,574.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		900,000.00	900,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	-262,804,574.80	-262,804,574.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
D08	Тайлант үеийн үр дүн		31,517,317.70	31,517,317.70
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	-231,287,257.10	-231,287,257.10

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,881,428,400.00	1,557,407,852.00	-324,020,548.00	82.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,881,428,400.00	1,557,407,852.00	-324,020,548.00	82.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,881,428,400.00	1,557,407,852.00	-324,020,548.00	82.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,012,400.00	80,963,681.00	-9,048,719.00	89.9
210102	Нэмэгдэл	82,171,600.00	74,360,681.00	-7,810,919.00	90.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,840,800.00	6,603,000.00	-1,237,800.00	84.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,801,400.00	9,517,964.00	-1,283,436.00	88.1
210201	Тэтгэврийн даатгал	7,201,000.00	5,917,564.00	-1,283,436.00	82.2
210202	Тэтгэмжийн даатгал	900,100.00	900,100.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	720,100.00	720,100.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	180,000.00	180,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,800,200.00	1,800,200.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,123,500.00	89,919,000.00	-1,204,500.00	98.7
210301	Гэрэл, цахилгаан	2,558,100.00	1,353,000.00	-1,205,100.00	52.9
210304	Байрны түрээс	88,565,400.00	88,566,000.00	600.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	18,240,000.00	14,902,025.00	-3,337,975.00	81.7
210401	Бичиг хэрэг	5,821,200.00	4,936,225.00	-884,975.00	84.8
210402	Тээвэр, шатахуун	6,890,400.00	4,445,800.00	-2,444,600.00	64.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,528,400.00	5,520,000.00	-8,400.00	99.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,493,900.00	7,347,300.00	-3,146,600.00	70.0
210604	Урсгал засвар	10,493,900.00	7,347,300.00	-3,146,600.00	70.0
2107	Томилолт, зочны зардал	9,217,800.00	614,400.00	-8,603,400.00	6.7
210702	Дотоод албан томилолт	9,217,800.00	614,400.00	-8,603,400.00	6.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,651,539,400.00	1,354,143,482.00	-297,395,918.00	82.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,650,796,900.00	1,353,747,482.00	-297,049,418.00	82.0
210803	Даатгалын үйлчилгээ	396,000.00	396,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00		-198,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	148,500.00		-148,500.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,881,428,400.00	1,557,407,852.00	-324,020,548.00	82.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,881,428,400.00	1,557,407,852.00	-324,020,548.00	82.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,881,428,400.00	1,557,407,852.00	-324,020,548.00	82.8

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5	5	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	-	100.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,534,834,970.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,534,834,970.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,534,834,970.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,345,508.00
210101	Үндсэн цалин	25,345,508.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,342,106,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,342,106,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,382,662.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	167,382,662.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,534,834,970.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,534,834,970.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,534,834,970.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

5 Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит</i>	
2019/03/13		Аудитын код:	САГ-2019/19/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Байгаль орчин, уур амьсгалын сан		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6
1	Тус сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй өр төлбөр нь 2014 оноос он дамжин бүртгэгдэж байгаа ба тайлант онд 12.8 сая төгрөгийг барагдуулж 279.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Өр төлбөрийн үлдэгдэлтэй харилцагч нарт тооцоо нийлэх хүсэлт явуулснаас 33.1 сая төгрөгийн авлагатай 5 харилцагч тус сантай тооцооны үлдэгдэлгүй талаар албан бичиг ирүүлсэн байна.	33.1	Зөвлөмж	2019 03.13	Захирал Нягтлан бодогч	Х.Ганбаатар Г.Одончимэг
2	Эко халаагуур нийлүүлэх тухай 2018 оны 18/350 дугаартай гэрээгээр Эрүүл мэнд-Интернейшнл байгууллагаас 2 загварын цахилгаан халаагуур нийт 622 ш хүлээн авахаас одоогийн байдлаар 500 ш хүлээн авч 122 ш эко цахилгаан халаагуур дутуу байна. Мөн тайлант хугацаанд БЗД, БГД-ийн 200 оршин суугчидтай гэрээ байгуулж эко халаагуур олгосныг тулган шалгахад баримт материал дутуу 2 хүн байна.	-	Зөвлөмж	2019 03.13	Захирал Нягтлан бодогч	Х.Ганбаатар Г.Одончимэг
Нийт		33.1				

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines provided for writing the summary.